



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/207

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан ард иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, эмнэлгийн тусламж үйлчилгээг хурдан шуурхай, чанартай хүргэх үйлсэд өөрийн хүч хөдөлмөр, сэтгэл оюунаа дайчлан хамт олноо манлайлан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Амаржих газрын нярайн их эмч Ц.Доржханд, Ц.Солонго, Мэдээгүйжүүлэл эрчимт эмчилгээний тасгийн их эмч Б.Анхбаяр нарыг Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 90000 төгрөг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 90000 төгрөг /ерэн мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/207 Ch
02 00395

Аймгийн Засаг даргын 2019 оны
03 дугаар сарын 28-ны өдрийн
А/207 дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН “ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ”-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Олгох шагнал
1	Ц.Доржханд	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Амаржих газрын нярайн их эмч	30000
2	Б.Анхбаяр	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Мэдээгүйжүүлэл эрчимт эмчилгээний тасгийн их эмч	30000
3	Ц.Солонго	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Амаржих тасгийн нярайн их эмч	30000
Дүн			90000

-oOo-